



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/Н/Ч

Алтай хот

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Хот, суурины ус, хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай хотод шинээр баригдах дулааны станцын I, II хэлхээний шугам сүлжээний трассыг 1-2 дугаар хавсралтаар баталж, хамгаалалтын бүсийг тэнхлэгээс 2 тийш 5 метрээр тогтосугай.

2. Шугам сүлжээний трасс, хамгаалалтын бүсэд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгогдсон шийдвэрүүдэд өөрчлөлт оруулж, газар чөлөөлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа хамгаалалтын бүсийн аюулгүй байдалд нөлөөлж, байгаа эсэх, хяналт тавих, бүсийн дэглэмтэй холбоотой мэдээллээр олон нийтийг хангахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас), захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

